



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/654

Номгон

Г Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр
хийгдэж байгаа барилга байгууламжийн
хяналтыг сайжруулах тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 85 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа барилга байгууламжийн хяналтыг эрчимжүүлэх, ажлын хэсэг, унаа машины аюулгүй байдлыг хангах зорилгоор LEXUS-470 2613 БНА, LEXUS-470 8663 БНА автомашины сэлбэг хэрэгсэлд шаардагдах 5.640.000 (Таван сая зургаан зуун дөчин мянган) төгрөгийг барилгын техник хяналтын зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

2. Худалдан авсан сэлбэг хэрэгслийг эргэлтийн хөрөнгийн бүртгэлд бүртгэхийг ерөнхий нягтлан бодогч С.Гэрэлмаад, хүлээлгэн өгөхийг нярав Г.Энхбаясгалан нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийтлэг үйлчилгээний алба (Ч.Түвшинжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210527